

Ноагийн ХӨВӨГЧ авдар

-Noahs Ark-



23 Page

Тайлбарлагч Адам, Ева хоёроос хойш олон жил өнгөрч, хүний тоо ч өсөн олширчээ. Гэтэл хүмүүсийн гэм нүглээс болж, газар дэлхий бузар муугаар дүүрэв. Үүнийг харсан Бурхан ихэд уурлан хилэгнэжээ.

Бурхан “Дэлхий хүчирхийлэл, бузар муугаар дүүрчээ. Би хүмүүсийг бүтээсэндээ маш их харамсаж байна. Би тэднийг газрын хөрснөөс арчин хаях болно”


Тайлбарлагч Гэхдээ тэдний дунд нэгэн зөвт хүн амьдарч байжээ. Түүнийг Ноа гэдэг. Ноа хөршөө хайрладаг, бас Бурханд ч хайртай нэгэн байлаа. Тэр үргэлж Бурхантай хамт байдаг байсан учраас Бурхан Ноаг сонгожээ.

Бурхан “Ноа, Би энэ газарт их бороог оруулж, сүйрүүлэх болно. Гэхдээ Би чамайг болон чиний гэр бүл мөн амьтай амьтан болгоноос хос хосоор нь амьд үлдээх болно. Чи уулын орой дээр хөвөгч авдар хий!”

Тайлбарлагч Ноа, Бурханы айлдсаны дагуу ус нэвтэрч орохооргүй том хөвөгч авдрыг хийж эхэлжээ. Тэгтэл хүмүүс Ноаг шоолж эхлэв.

Эрэгтэй “Ус байхгүй уулын оройд хөвөгч авдар хийж байх чинь... Энэ Ноа галзуурсан байх аа!

Эмэгтэй “Хихихи.. харин тийм ээ, бүр дээр нь энэ дэлхий дээр маш их бороо орно гэсэн шүү дээ. Тэнгэр ийм цэлмэг байхад хаанаас тэгж их бороо орох вэ дээ~”




24 Page

Тайлбарлагч Ноа Бурханы зааврын дагуу бүх амьтад хос хосоороо орж чадах том хөвөгч авдар хийжээ.

Бурхан Өнөөдрөөс эхлэн долоо хоногийн дараа дөчин өдөр, дөчин шөнө тасралтгүй бороо орох болно.

Тайлбарлагч Бурханы айлдсан өдөр бүх төрлийн амьтад хөвөгч авдранд оржээ. Заан, арслан, анааш, тэнгэрийн шувууд гэх мэт. Хөвөгч авдар амьтдаар дүүрэв. Хөвөгч авдарт орсон хүмүүс нь Ноа болон түүний эхнэр, гурван хүү Шем, Хам, Иафат, гурван бэр нийлээд 8 хүн л байлаа.



25 Page

Тайлбарлагч Хөвөгч авдрын хаалга хаагдангуут, тэнгэрээс бороо орж эхлэв. Тэнгэрт нүх гарсан мэт өдөр шөнөгүй тасралтгүй бороо асгарав. Дөчин өдрийн дараа бороо зогсоход дэлхий тэр чигээрээ усанд автсан байлаа. Хөвөгч авдранд байгаа Ноагийн гэр бүл, амьтдаас гадна өөр юу ч үлдсэнгүй.



26 Page



27 Page

.....

Тайлбарлагч Бороо орж эхлээд дөч хоносны дараа зогсов. Бүх дэлхий усаар бүрхэгдсэн бөгөөд юу ч харагдахгүй байлаа. Гэхдээ хөвөгч авдарт байсан Ноагийн гэр бүл ба амьтад аюулгүй тайван байсан. Нэгэн өдөр, Ноа тагтаагаа гаргаж нисгэв. Тэгтэл түүнд суух газар олдоогүй тул буцаж ирэв. Долоо хоногийн дараа дахин нисгэв. Энэ удаа чидун модны шинэхэн нахиа зуусан байжээ. Ийнхүү Ноа газрын ус татарсныг мэдэв.

.....

Тайлбарлагч Үер болсноос хойш гурван зуун далан хоног өнгөрч, газар хатсаны дараа Бурхан Ноад хандан айлдав.

Бурхан Ноа, чи гэр бүлийнхээ хамт хөвөгч авдраас гарч болно

Тайлбарлагч Ноа гэр бүлийнхээ хамт хөвөгч авдарнаас гарав. Амьтад ч бас түүний араас гарцгаалаа. Ингээд Ноа Бурханд талархлын шатаалт тахил өргөв.

Бурхан Би дахин хэзээ ч хамаг амьтныг үерийн усанд устгахгүй.

Тайлбарлагч Бурхан тэнгэрт маш үзэсгэлэнтэй солонго татуулаад энэ солонго бол Би дахин хэзээ ч мах цустай бүхнийг устгах үер буулгахгүй гэсэн “амлалтын тэмдэг” хэмээжээ.